

БАТЛАВ:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



М.БАЯРМАГНАЙ

“ХОТ ХООРОНДЫН ДАЙВАР АЧАА, КАРГО АЧААНЫ ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ
БҮРДҮҮЛЭХ СУДАЛГААНЫ АЖИЛ”-ЫН
АЖЛЫН ДААЛГАВАР

20²⁶ оны ⁰⁶ -р сарын ¹⁶ -ны өдөр

Дугаар: 09

Улаанбаатар хот

№	Агуулга	
1.	Гүйцэтгэх ажлын нэр	Хот хоорондын дайвар ачаа, карго ачааны тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хянах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх судалгааны ажил
2.	Ажил гүйцэтгэх үндэслэл, хэрэгцээ шаардлага	Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын бичигт “Монгол Улс 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болно” гэж тодорхойлсон. Уг бодлогын баримт бичгийн дөрөвдүгээр бүлгийн эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийн зорилт 4.1.16-д “Дамжин өнгөрүүлэх тээвэр, худалдаа, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг тээвэр, логистик, хилийн дэд бүтцийн хамт байгуулан эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангана” гэж, зорилт 4.2.2-д “Хөдөө аж ахуй, тээвэр логистик, төрөлжсөн аялал жуулчлалын салбарыг бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих замаар хөгжүүлнэ” гэж, зорилт 4.4.2-т “Бараа, үйлчилгээг худалдах, тээвэрлэх, хянах, хөрөнгө оруулах, зах зээлд нэвтрэх нөхцөлүүдийг ил тод болгох, бүртгэл ба мэдээллийн нэгдсэн системийг бий болгох, цаасгүй технологи нэвтрүүлэх, эрсдэлд суурилсан удирдлага ба хяналтыг бий болгоно” гэж, зорилт 5.3.9-д “Цахим бизнес, цахим болон зайн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого боловсруулж хэрэгжүүлнэ” гэж, зорилт 8.1-д “Бүс нутгийн эдийн засгийн интеграцад дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр бүрэн холбогдож, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлнэ” гэж, 8.1.4-д “Олон улсын тээвэр логистикийн 3, бүсийн тээвэр логистикийн 6, орон нутгийн тээвэр логистикийн 33 төвийг тус тус барина” гэж тус тус тусгагдсан.

		Хот хоорондын тээвэрт хувь хүмүүс (пронто, портер, хот хоорондын автобус, такси) дайвар ачааг гар дээрээс авч тээвэрлэх явдал хэвшил болоод байна. Энэ нь ачаа үрэгдэх, эвдрэх, хариуцлага хүлээх эзэнгүй болох, иргэдийн хохирлыг барагдуулах зохицуулалтгүй, хууль бус ачаа, бараа тээвэрлэх зэрэг маш олон эрсдлийг бий болгож байна.
3.	Захиалагч байгууллага	Зам, тээврийн яам (Автотээврийн бодлого зохицуулалтын газар)
4.	Ажлын хамрах хүрээ	Автотээврийн салбар
5.	Ажил хэрэгжүүлэх хугацаа	Судалгааны ажлыг Зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулснаас хойш 6 сарын хугацаанд хийж гүйцэтгэнэ: Эхлэх: 2026 оны 06 дугаар сарын 25 -ны өдөр Дуусах: 2026 оны 11 дүгээр сарын 25 -ны өдөр
6.	Ажлын зорилго	Хот хоорондын дайвар ачаа, карго ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах, хянах эрх зүйн орчныг сайжруулах арга замыг тодорхойлно. Энэ хүрээнд хууль эрх зүйн бичиг баримтын төсөл ба тээвэр зохион байгуулалтын талаарх зөвлөмж, дүгнэлтийг боловсруулна.
7.	Ажлын арга зүй	- Монгол Улсад мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомжийг баримтлан, шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааны арга зүй, аргачлал ашиглах; - Орчуулгын ажилд мэргэжлийн болон техникийн үг хэллэгийг оновчтой сонгох.
8	Гүйцэтгэх ажил	- Өнөөгийн нөхцөл байдлын судалгааг хийх: - Хот хоорондын ачааны урсгал, эрэлт нийлүүлэлтийн өнөөгийн байдал; - Хот хооронд ачаа тээвэрлэлт гүйцэтгэж буй ААНБ, хувь хүний талаарх мэдээлэл, үүнээс дайвар болон карго ачаа тээвэрлэлт гүйцэтгэж буй ААНБ, хувь хүний талаарх мэдээлэл; - Хот хоорондын ачаа тээвэрлэлт гүйцэтгэж буй тээврийн хэрэгслийн мэдээлэл, үүнээс дайвар болон карго ачаа тээвэрлэлт гүйцэтгэж буй тээврийн хэрэгслийн мэдээлэл; - Дайвар ба карго ачааны үүсэх ба шингэх цэгийг тодорхойлох; - Дайвар ба карго ачаа тээвэрт ашиглагдаж буй програм хангамж, системийг судлах; - Ачаа тээврийн (дайвар ба карго ачааг оролцуулан) үнэ тарифын судалгаа; - Ачаа тээврийн (дайвар ба карго ачааг оролцуулан) хугацаа ба саатал; - Бусад шаардлагатай мэдээлэл; - Хэрэглэгч (ачаа илгээгчид, хүлээн авагч, жолооч, каргоны компани, хяналтын байцаагч нар г.м)-

		ийн судалгаа авах, үр дүнг судлах, дүгнэлт, зөвлөмж боловсруулах; - Монгол Улсад мөрдөгдөж буй ачаа тээврийн үйлчилгээтэй холбоотой эрх зүйн бичиг баримтууд (хууль, дүрэм журам, стандарт г.м)-ыг судлах; - Бусад орны дайвар ба карго ачааны тээвэр зохион байгуулалтын сайн туршлагыг судлах; - Дайвар ба карго ачааны тээвэр зохион байгуулалтын үйлчилгээнд ашиглагдаж буй технологийн шийдлийг судлах; - Хот хоорондын дайвар ачаа, карго ачааны тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хянах эрх зүйн зөвлөмжийг боловсруулж, эрх зүйн бичиг баримтын төсөл боловсруулах; - Хот хоорондын дайвар ачаа, карго ачааны тээвэрлэлтийн үйлчилгээний тээвэр зохион байгуулалтын талаар бодлогын зөвлөмж боловсруулах.
9.	Ажлын үр дүн, бүтээгдэхүүн	- Хот хоорондын дайвар ачаа, карго ачааны тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хянах эрх зүйн бичиг баримтын төслийг бэлтгэх. - Хот хоорондын дайвар ачаа, карго ачааны тээвэрлэлтийн үйлчилгээний тээвэр зохион байгуулалтын талаар бодлогын зөвлөмж гаргах.
10.	Шаардагдах санхүүжилт	20,000,000 төгрөг /авто замын норм, нормативын сан/
11.	Ажил гүйцэтгэгчид тавигдах шаардлага	Голлох мэргэжилтэнд тавигдах шаардлага: <u>Багийн ахлагч/ Тээврийн мэргэжилтэн (1 хүн):</u> Судалгааны ажлыг хэрэгжүүлэх гэрээ баталгаажсан үеэс эхлэн хэрэгжилтийг зохион байгуулж, энэхүү ажлын даалгаварт тусгасан ажлыг бүрэн хэмжээнд чанартай гүйцэтгэн зөвлөхүүдийн хийх ажилд хяналт тавих, хийх ажлыг төлөвлөх, тайлан гаргахад хяналт тавьж, холбогдох байгууллагуудаас санал авах, санал зөвлөмжийг тайланд тусгах ажлуудыг зохион байгуулан, ажлыг гэрээнд заасны дагуу хугацаанд нь гүйцэтгэх хариуцлага хүлээнэ. Эрх зүйн бичиг баримтуудын хувилбарын уялдааг хангана. Мөн тайлангийн явц, эцсийн тайлангийн талаар санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулна. Багийн ахлагч нь автотээврийн салбарт 15-аас доошгүй жил зөвлөх үйлчилгээ, техникийн бичиг баримтын боловсруулах, батлуулах ажлыг гүйцэтгэсэн туршлагатай, доктор (Ph.D), зөвлөх инженер хүн байна. <u>Ачаа тээвэр, логистикийн болон гэрээ эрх зүйн чиглэлийн мэргэжилтэн 2):</u> Ажлыг хэрэгжүүлэх гэрээ баталгаажсан үеэс эхлэн хэрэгжилтийг зохион байгуулж, энэхүү ажлын даалгаварт тусгасан ажлыг бүрэн хэмжээнд чанартай гүйцэтгэх, автотээврийн болон гэрээ, эрх зүйн чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан, судалгаа шинжилгээний ажил хийсэн туршлагатай хүн байна.

12.	Ажлын гүйцэтгэл тайлангийн үе шат	1. Ажлын даалгаварт тусгагдсан холбогдох мэдээлэл, судалгаанд үндэслэн тайланг боловсруулж Захиалагчид танилцуулах, судалгааны ажлын эцсийн тайлангийн төслийг боловсруулах, АТБЗГ-аас өгсөн санал зөвлөмжийг тусган эцэслэн гүйцэтгэнэ. 2. Судалгааны ажлыг дараах байдлаар тайлагнах бөгөөд тайлангууд нь доорхи агуулга, бүтэцтэй байна. Үүнд: а. <u>Эхлэлийн тайлан</u>: Гэрээ байгуулснаас хойш ажлыг эхлүүлэх талаар авсан арга хэмжээ, гэрээнд заасны дагуу ажлаа хэрхэн эхэлсэн, бусад хамтран ажиллах зөвлөхүүд ажлаа эхлүүлсэн зэргийг нотолж, цаашдын ажлын төлөвлөгөөг боловсруулж тодорхойлсон байна. Тайлант хугацаа нь: 2026 оны 07 дугаар сарын 30-ны өдөр б. <u>Дундын тайлан</u>: Гэрээний дагуу гүйцэтгэж байгаа судалгааны ажлын үр дүн, дэвшүүлж буй санал, зөвлөмж зэргийг тодорхой зааж, холбогдох хавсралт, мэдээллүүдийг нарийвчлан тусгасан байна. Тайлант хугацаа нь: 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдөр в. <u>Эцсийн тайлан</u>: Энэхүү тайланд эхлэлийн болон дундын шатны тайлангуудад хийсэн ажлуудаа нэгтгэж, эцсийн үр дүнд авч байгаа санал, дүгнэлтээ нэгтгэсэн байна. Тайлант хугацаа нь: 2026 оны 11 дүгээр сарын 20 -ны өдөр 3. Судалгааны ажлын дундын шатны тайланг хүлээлгэн өгсний дараагаар олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулах; 4. Судалгааны ажлын эцсийн тайланг Автотээврийн салбарын ШУТ-ийн дэд зөвлөлөөр хэлэлцүүлсний үндсэн дээр хууль тогтоомжийн дагуу холбогдох актыг үйлдэн, хүлээлгэн өгнө.
-----	-----------------------------------	--

ХЯНАСАН:

ТЗУГ-ЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

С.МЯНДАСМАА

БОЛОВСРУУЛСАН:

АТБЗГ-ын шинжээч

Ц.Баяржаргал